



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/636

Булган сум

Г Төслийн жагсаалт батлах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” батлах тухай 113 дугаар тогтоолын 11.5.7, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/240 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-ийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах аймгийн Дэд хорооны 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу санхүүжүүлэх төслүүдийг эрэмбэлсэн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хоршооны мэдээллийг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэхийг дэд хорооны дарга Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д даалгасугай.

3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар ирүүлсэн төсөл, олгосон зээлийн тайлан, мэдээллийг нэгтгэн журамд заасан хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010879

**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт
багтсан санхүүжүүлэх төслийн жагсаалт**

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Регистрийн н дугаар	Оршин суугаа газрын хаяг	Салбар, чиглэл	Төслийн нэр	Баталсан санхүүжилт /төгрөг/	Нийт үнэлгээ	Эрэмбэлсэн жагсаалт	Код
1	"Эко хан буян" хоршоо	3190617	Хангал сумын 2-р баг	Эрчимжсэн мал аж ахуй	"Цэвэр үүлдрийн үхрийн эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх"	100,000,000	232.2	1	SME-25-01876
2	"Баяжих майхан толгой" хоршоо	3207927	Хангал сум 2-р баг урт	Эрчимжсэн мал аж ахуй	"Хангалын баян сүрэг"	100,000,000	211.5	2	SME-25-01873
3	"Халзан үнээт чулуут" хоршоо	3210928	Хангал сум хялганат малчид 150 тоот	Эрчимжсэн мал аж ахуй	"Махны чигтэлийн цэвэр үүлдрийн сэлэнгэ үхэр өсгөх, цөм сүрэг бий болгох"	90,000,000	185.3	3	SME-25-01872
Нийт						290,000,000			

